Erasmus+

MELINC

Тэгш хамруулах боловсрол ба МХХТ

Багш: Л.Мөнхтуяа (Доктор (Ph.D), дэд проф)

2023 он

1

# Агуулга


1 Яагаад тэгш хамруулах сургалт гэж?

2 Тэгш хамруулах боловсрол ба МХХТ-ийн бодлого, орчин

3 Сургуулийн МХХТ-ийн зөөлөн ба хатуу дэд бүтэц

4 Боловсролын тусгай хэрэгцээтэй суралцагчдыг МХХТ-ээр дэмжих боломж, туршлага

5 Тулгамдаж буй асуудал, шийдэх арга зам

6 Дүгнэлт


2

## 1. Яагаад тэгш хамруулах сургалт гэж?

Боловсролын дэлхийн чуулга уулзалт (2015) :
Инчоны тунхаглал "Боловсрол 2030"



"Тэгш хамран сургах, тэгш боломж бүхий чанартай боловсрол, бүх нийтийн насан туршийн суралцахуйг дэмжих"

160 орон
(1600 төлөөлөгч)

**Яагаад ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ гэж?**

- Хүүхдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн
- "Хүүхэд төвтэй" сургалт
- Тэгш, хүртээмжтэй орчин (тухайн газар, нутаг)-ыг бий болгох
- Бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх үр өгөөжтэй арга зам
- Хэн ч бай, "нийгэм"-ийнхээ үнэ цэнэтэй нэгэн байх
- Оролцох, холбогдох, үнэлэгдэх боломжтой байх

3

## 1. Яагаад тэгш хамруулах сургалт гэж?

Тэгш хамруулан сургах боловсрол:
Тулгамдаж буй аливаа бэрхшээлийг сайн туршлагад тулгуурлан шийдвэрлэхэд оршино.

БСШУС- ын сайдын 2018.03.29 ний өдрийн А/155 тоот "Үлгэрчилсэн загвар, аргачлал батлах тухай" тушаал:
1-р хавсралт: ГСТ-ний үлгэрчилсэн загвар,
2-р хавсралт: ГСТ боловсруулах аргачлал

"ГСТ нь хүүхэд бүрийн хөгжлийн онцлог, хэрэгцээнд нийцсэн арга зүй, дэмжлэгийг үзүүлэх хэрэглэгдэхүүн бөгөөд тухайн хүүхдэд чанартай боловсрол олгох нөхцөл боломжийг бүрдүүлэх арга зам"




*Э х сурвалж: Ч. Оюунбилэг СУИС Ялгаатай суралцахуйн арга зү*

4

## 2. Тэгш хамруулах боловсрол ба МХХТ-ийн бодлого, орчин

Асуулт 1. Тэгш хамруулах боловсрол, түүнийг МХХТ, зайн сургалтаар дэмжих талаар бодлогын баримт бичигт тусгасан уу?

| Монгол Улс | Боловсрол | Боловсролын хууль | МУБИС |
|---|---|---|---|
| - "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын I үе шат (2021-2030)-ны "Хүн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлж, **тэгш хамруулах тогтолцоог шинэчлэх**"<br>- Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан "**Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж**, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлэх<br>... | Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө: "Монгол Улсын иргэний хөгжлийн хэрэгцээг хангахуйц **чанартай, нээлттэй, тэгш хүртээмжтэй, уян хатан боловсролын үйлчилгээнд тулгуурлан мэдлэгт суурилсан нийгэм болон дижитал технологийн эринд ажиллаж амьдрах** нийгмийн идэвхтэй оролцоо бүхий, тасралтгүй хөгжих чадамжтай иргэн ийг цогцоор нь хөгжүүлэх"<br>БСШУСЯ: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ЕБС-д тэгш хамран сургах журам<br>БШУЯ: Цахим сурах бичиг, Ерөнхий боловсролын сургалтад ашиглах нээлттэй материалд тавих шаардлага батлах тухай (3.3 **Цахим сурах бичгийн тусгай шаардлага**)<br>... | Боловсролын ерөнхий хууль:<br>12.8. Багш бэлтгэх сургалтын **хөтөлбөрт багшид тусгай, ялгаатай хэрэгцээ бүхий суралцагчтай** ажиллах тусгайлсан арга зүй, ур чадварыг эзэмшүүлэх агуулгыг заавал тусгана<br>14.8. Боловсролын хөтөлбөр, агуулгыг цахим хэлбэрт шилжүүлж хөгжүүлнэ.<br>ДОЛООДУГААР БҮЛЭГ БОЛОВСРОЛЫН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН, АЮУЛГҮЙ БАЙДАЛ<br>Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 16.1: Багш бэлтгэх их, дээд сургууль, коллежийн **сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй суралцагчтай ажиллах агуулга, арга зүйг тусгана**<br>.... | - МУБИС Сургалтын журам Г. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад үзүүлэх үйлчилгээ<br>- **МУБИС-д сурч буй оюутнуудад: "Тэгш хамруулах боловсрол", "Тусгай хэрэгцээт боловсрол" хичээлийг заавал болон сонгон судлах хичээл**<br>- Тусгай хэрэгцээт боловсролын тэнхим (Онлайн сургалт)<br>- БаС Хүүхдийн хөгжлийг дэмжих төв<br>... |

5

## 2. Тэгш хамруулах боловсрол ба МХХТ-ийн бодлого, орчин

**Асуулт 2. Тэгш хамруулах сургалтыг дэмжих дэвшилтэт технологийн орчин, дэд бүтэц хангалттай юу?**

Теле хичээл бүтээх ажил

710

БШУЯ, харъяа байгууллага
Монголын телевизүүдийн холбоо- 16 телевиз (170 ажилтан)
СӨБ-ын 20 багш
ЕБС-ийн 314 багш

Тусгай хэрэгцээт боловсролын 28 багш, дохионы хэлний орчуулагч, хэлмэрч 20 багш [9]

Бүх теле хичээлүүдийг дохионы хэлний орчуулгатай;
Бага ангийн зарим теле хичээл үндэсний цөөнхөд зориулж казах, тува хэлний орчуулгатай (www.medle.mn)

Гэвч ... улсын хэмжээнд 4.7 мянган өрх цахилгаангүй байна. Цахилгаангүй өрхийн 93.5 хувь нь гэрт амьдарч байгаагийн дотор 76.8 хувь нь хөдөө оршин суудаг ажээ [8].

Суралцагчдын мэдээлэл хүлээж авах тэгш байдал, хүртээмж ялгаатай байсаар байна.

6

## 2. Тэгш хамруулах боловсрол ба МХХТ-ийн бодлого, орчин

Тэгш хамруулах боловсрол нь хамтдаа сурах, өсөх, хөгжих бүх хүүхэд , залуусын ялгаатай байдлыг хангахад чиглэнэ.




*Эх сурвалж: Emmanuel de Dinechin, Alizée Boutard Information an[d] Communication Technologies (ICTs) and Inclusive Education 202[...]*

7

## 2. Тэгш хамруулах боловсрол ба МХХТ-ийн бодлого, орчин

*Тэгш хамруулах сургуулийн сургалтын бүрэлдэхүүн*

| Багштай харилцах | Бусад суралцагчидтай харилцах | Хэвлэмэл материал үзэх | Аман материал ашиглах |
|---|---|---|---|
| - Багш дохионы хэл ашиглах<br>- Ангид дүрслэл ба<br>- альтернатив харилцаа (ААС) ашиглах<br>- Багш тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах | - Сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй дохионы хэлээр харилцах<br>- Ангид дүрслэл ба<br>- альтернатив харилцаа<br>- (ААС) ашиглах | - Сурах бичгийг том хэмжээтэй хэвлэх эсвэл брайль ном<br>- Анги танхимд хүүхдийг<br>- хэрэгцээнд нь нийцүүлэн суулгах (цонх самбар) | - Ашиглаж буй аман<br>- материалд тайлбар бичих<br>- Сонсголын<br>- бэрхшээлтэй сурагчдад зориулж,<br>- дохионы хэл оруулах |
| **Бичвэрээр өөрийгөө илэрхийлэх** | **Яриагаар өөрийгөө илэрхийлэх** | **Хичээлийг сэргээн санахын тулд тэмдэглэл хөтлөх** | **Боловсролын контент/ хэрэгсэлд хандах** |
| - Багш брайль уншдаг байх<br>- Хөдөлгөөний бэрхшээлтэй суралцагчдад зориулсан тохиромжит ширээ, үзэг ...<br>- Бичихэд туслах бусад хэрэгслийн бэлэн байдал | - Багш дохионы хэлтэй<br>- байх<br>- Дохионы хэлд буулгах чадвар<br>- Хугацааны тохируулга (өргөтгөсөн цаг) | - Тэмдэглэл хөтлөхөд дэмжлэг үзүүлэх туслагчтай байх<br>- Perkin Брайль машин ашиглах | - Видео материалд бичвэр болон дохионы хэл оруулах<br>- Компьютер, тоног төхөөрөмжийг ашиглах<br>- Брайль дүрс, график |

8

## 3. Сургуулийн МХХТ-ийн дэд бүтэц

МХХТ-ийн тусгай хэрэгцээнд зориулсан программын хэрэгслийн төрөл:

1. *Орлуулах*
2. *Сурган хүмүүжүүлэх*
3. *Харилцаа холбоо*

МХХТ-ийн дэмжлэг- Тэгш хамруулах боловсрол

1. Иргэн бүр бүх шатны боловсрол эзэмших, насан турщдаа суралцах боломжийг тэгш хангах, *МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ НЭЭЛТТЭЙ* байх
2. МХХТ-ийг *ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН УР ЧАДВАРЫГ* илрүүлэхэд туслах, ашиглах нөхцөлийг бүрдүүлэх
3. *ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛД МХХТ-ИЙН ХЭРЭГЛЭЭГ БИЙ БОЛГОХОД* сургагч багш, ажилтнуудыг мэргэшүүлэх
4. МХХТ-ийн хэрэглээ болон үр өгөөжийн талаар *СУДАЛГАА ХИЙЖ, ҮР ДҮНД СУУРИЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ*
5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролд *МХХТ-ИЙГ НЭВТРҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР СУДАЛГАА ХИЙХ, МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ, ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ СИСТЕМ БИЙ БОЛГОХ*

9

## 3. Сургуулийн МХХТ-ийн дэд бүтэц




"Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим"-д байвал зохих хэрэглэгдэхүүн, туслах хэрэгслийн жагсаалт

1. Ширээ, сандал /шаардагдах тоогоор/
2. Цагаан самбар 1ш
3. Компьютер 1ш
4. Принтер 1ш
5. Хувилагч 1ш
6. Телевиз
7. Номын тавиур, шүүгээ
8. Харааны бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад байвал зохих хэрэгсэл
- хараа шалгах энгийн хэрэгсэл буюу самбар
- цагаан таяг
- таягны гэрэлтүүлэгч цаас
- ярьдаг ном
- самбар
- шивүүр
- брайль хэлний цагаан толгой
- брайлийн цаас
- брайль бичгийн хэрэгсэл
- брайль шатар
- брайль даам
- сул хараатай хүний дэвтэр
- брайль самбин
- томруулагч шил
- Товгор дэлхийн бөмбөрцөг
- Дейзи ном уншигч
- модон баллуур
- зурган карт
- хурууны мэдрэмж сайжруулах тоглоом /хатуу, зөөлөн, арзгар, хэвсгэр/ гэх мэт
9. Сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад байвал зохих хэрэгсэл
- сонсголын аппарат
- сонсгол шалгах хэрэгсэл
- сонсгол хөгжүүлэх дасгалын ном
- төрөл бүрийн дуу авиа бичлэг CD-нүүд
- авиа тавих ном
- Магнитофон
- Дохионы хэлний толь бичиг
- Дохионы хэлний зурагт үзүүлэн
- Үлгэрийн ном,
- Зурган карт гэх мэт

- БСШУС-ын сайдын тушаал хэрэгжиж байна.
- Хүүхдийн хөгжлийг дэмжих танхимд шаардлагатай, дэмжлэг МХХТ-ийн хэрэгсэл хангалтгүй байна.

10

## 3. Сургуулийн МХХТ-ийн дэд бүтэц

Ерөнхий боловсролын сургуульд суралцдаг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид




*Эх сурвалж: https://beta.1212.mn/mn/statistic/statcate/573057/table-view/DT_NSO_2002_058V1*

ЖИШЭЭ:

| БОЛОВСРОЛЫН ТЭГШ БУС БАЙДАЛ | | |
|---|---|---|
| ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ | | |
| | *102 дугаар сургууль* | *33 дугаар сургууль* |
| Нийт сурагч | 1500 | 4200 |
| Нийт багш | 75 | 154 |
| Нэг багшид ногдох сурагчийн тоо | Бага ангид 38, дунд ахлах ангид 14 | Бага ангид 47, дунд ахлах ангид 20 |
| ИЖИЛ ТӨСТЭЙ БАЙДАЛ | | |
| Үдийн цай | Үдийн цайны нормд заасны дагуу оруулж хийдэг | |
| Сурагчдын компьютерийн хэрэглээ | Зөөврийн 20 суурин 15 | Зөөврийн 40 суурин 10 |
| ЯЛГААТАЙ БАЙДАЛ | | |
| 1 компьютерт ногдох хүүхдийн тоо | 20 | 46 |
| Гадаах спортын талбай | Байхгүй | Байгаа |

*Эх сурвалж: https://mpress.mn/p/6417*

11

## 4. Боловсролын тусгай хэрэгцээтэй суралцагчдыг МХХТ-иор дэмжих боломж, туршлага

Тэгш хамруулах анги ба МХХТ-ийн үүрэг:

- Суралцагчийн бие даан сурах үйлийг дэмжих;
- Боловсролын тусгай хэрэгцээтэй суралцагчдын далд боломжуудыг нээх;
- Суралцагчдад мэдсэн, сурсан зүйлээ илэрхийлэх;
- Даалгаврыг хувь суралцагчийн онцлог, ур чадвар, чадварт нийцүүлэн тохируулах боломжийг олгоно.

12

## 4. Боловсролын тусгай хэрэгцээтэй суралцагчдыг МХХТ-иор дэмжих боломж, туршлага

**Асуулт 6. Зайн (Цахим) сургалтад суралцахуйн бэрхшээлтэй суралцагчдын оролцоо, сорилт үүссэн бэ?**

Танхимын сургалтын үеэр багш нь хөгжлийн бэрхшээлтэй сурагчийн онцлогийг харгалзан дасгал, гэрийн даалгавраа зохицуулан тусгайлан бэлтгэж өгдөг байсан бол алсын зайн сургалтын явцад ийм боломж байхгүй болсон гэж эцэг эхчүүд үзсэн байна [11].

https://www.youtube.com/watch?v=tSkzbamlP0E




Суралцагчид багштай харилцах харилцаа, эргэх холбоо, даалгаврын зааварчилгаа чухал гэжээ.

13

## 4. Боловсролын тусгай хэрэгцээтэй суралцагчдыг МХХТ-иор дэмжих боломж, туршлага

Хараааны бэрхшээлтэй суралцагчдын түгээмэл ашиглаж байгаа хэрэглэгдэхүүн

Самбар, шивүүр, цаас, брайль бичгийн машин







ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ СУРАЛЦАГЧДАД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД:
Сургалтын хэрэглэгдэхүүн

14

## 4. Боловсролын тусгай хэрэгцээтэй суралцагчдыг МХХТ-иор дэмжих боломж, туршлага

Монгол хэлээр хөгжүүлсэн
туслагч технологид суурилсан шийдлүүд









EPUB

E-PUB

**Монгол хэл**

1.Танин мэдэхүйн брайль сургалтын хэрэглэгдэхүүн

2.Дэлгэц уншигч программ

3.Цахим брайль төхөөрөмж

4.Цахим ном уншигч төхөөрөмж

5.Хүртээмжтэй форматын ном хэвлэл

*Эх сурвалж:М.Цэнгэл "Хараагүй хүмүүсийн инноваци хөгжлийн төвийн тэргүүн"*

15

## 4. Боловсролын тусгай хэрэгцээтэй суралцагчдыг МХХТ-иор дэмжих боломж, туршлага

МУБИС-ийн Тусгай хэрэгцээт боловсролын тэнхим

**Хичээл (Заавал болон сонгон судлах):**
- Тэгш хамруулах боловсрол (2.0 кр)
- Тусгай хэрэгцээт боловсрол (2.0 кр)
- Бусад





МУБИС, ТХБ-ын тэнхим
Брайль ном



**Материаллаг баазын дэмжлэг**
- АХБ, Дээд боловсролын шинэчлэлийн төсөл
- Юнисеф, Боловсролын бодлого төсөл
- Нээлттэй нийгэм-форум төсөл
- Японы Хёго ИС
- ЖАЙКА "Явуулын багш"
- МУБИС
- ...

16


5. Тулгамдаж буй асуудал, шийдэх арга зам
Тэгш хамруулах сургалтад МХХТ-д суурилсан Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө хэрэгжүүлэх арга зүйн шинэчлэлт хэрхэн хийх?
Тэгш хамруулах сургалтад сурахуйн үйлийг дэмжих МХХТ, техник хэрэгслийн хангалтын судалгаа хийх, нөхцөлийг сайжруулах
СОРИЛТ
АСУУДАЛ
ОРЧИН
ЦАХИМ БАГШЛАХУЙ
"Хүүхэд бүр тэгш, хүртээмжтэй байдлаар боловсрол эзэмшиж чадаж байна уу?
Багш МХХТ ашиглан цахимаар харилцах нь "багш-сурагч", "сурагч-сурагч", "эцэг эх-багш"-ийн ТУСГААРЛАГДСАН ОРОН ЗАЙ-г багасгах

17


5. Тулгамдаж буй асуудал, шийдэх арга зам
Юуг хэрхэн өөрчлөх вэ?
- Сургуулийн зохион байгуулалт
- Сургалтын хөтөлбөр, тохируулга
- Арга зүйн стратеги төлөвлөгөө
- Тусгай техник, хэрэгсэл
- Үнэлгээ
Эмгэг
Согог
Бэрхшээл
...
Оролцоо
Чадвар
Хөгжил
Эрүүл мэнд
Нийгэм
1. СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ
2. СЭТГЭЛГЭЭ

18


5. Тулгамдаж буй асуудал, шийдэх арга зам
Асуулт 7. Тэгш хамрагдах боловсролыг дэмжихэд зайн (цахим) сургалтын хүртээмж, чанарыг дээшлүүлэх ямар шийдэл байж болох вэ?
ҮНДЭСНИЙ ДЭД БҮТЭЦ
- Интернэт, сүлжээ
- Үндэсний "нээлттэй контент"-ийн платформ үүсгэх
- Тэгш хамруулах боловсролын контент бүтээгчдийг дэмжих системтэй болох
- Тэгш хамруулах сургалтын контент бэлтгэх санхүүжилтийг нэмэх
СУРГУУЛИЙН ДЭД БҮТЭЦ
- Интернэт, сүлжээ
- Суралцахуйн бэрхшээлийг харгалзсан,
- суралцах боломжийг дэмжих тоног төхөөрөмж, хэрэгслээр хангагдах
- Зорилтот бүлгийн суралцагчдад зориулсан "нээлттэй хичээл"-ийн сан үүсгэх
- Хүний нөөц болон суралцагчдын сурах таатай орчин бий болгох
ICT
INFORMATION
COMMUNICATION
TECHNOLOGY
Зургийн эх сурвалж: https://leadschool.in/blog/ict-in-education-how-it-is-transforming-learning/

19


5. Тулгамдаж буй асуудал, шийдэх арга зам
Асуулт 7. Тэгш хамрагдах боловсролыг дэмжихэд зайн (цахим) сургалтын хүртээмж, чанарыг дээшлүүлэх ямар шийдэл байж болох вэ?
СУРАЛЦАГЧИЙН дэмжлэг
- Интернэт, сүлжээгээр хангагдах
- Зорилтот бүлгийн суралцагч суралцах боломжийг дэмжих тоног төхөөрөмж, хэрэгслээр хангагдах
- Сургуулийн багш, ажилтан тоног, төхөөрөмж ашиглах заавар, зөвлөгөө өгч дэмжих
- Ганцаарчилсан сургалтад хамрагдахад багш, асран хамгаалагчдын хамтын дэмжлэг, уялдаа холбоо
БАГШИЙН арга зүй
- Интернэт, сүлжээ
- Боловсролын тусгай хэрэгцээг харгалзсан, суралцах боломжийг Дэмжих тоног төхөөрөмж, хэрэгслийг ашиглах арга зүйд суралцах
- Зайн (Цахим) сургалт зохион байгуулах арга зүйд суралцах
- Зааж буй хичээлийн хүрээнд суралцагчдад зориулсан "цахим", "үзүүлэх хичээл"-ийг хамтран бэлтгэх, хэрэгжүүлэх
ХАМТЫН АЖИЛЛАГАА
- Бүх шатны боловсролын байгууллагууд тэгш хамруулах боловсролын чанарыг дээшлүүлэх чиглэлээр хамтран ажиллаж, сургалтын нээлттэй нөөц материалыг хөгжүүлэх
- Сургалтын тоног төхөөрөмж ашиглах заавар, удирдамж гаргах
- Дотоод, гадаад байгууллагын хамтын ажиллагаанд суурилж, "уншдаг ном", "сонсдог ном" бүтээх

20

## 6. Дүгнэлт, санал

1. БШУЯ-наас тэгш хамруулах боловсролыг дэмжих бодлого, баримт бичиг боловсруулан хэрэгжүүлж байна.
2. СӨБ, ЕБ-ын сургалтыг “теле хичээл” хэлбэрээр зохион байгуулсан ч МХХТ-ийн дэд бүтэц, тухайн суралцагчийн материаллаг боломж (гар утас, телевиз), бусад хүчин зүйлээс хамаарч хоцрогдол үүссэн.
3. Багш бэлтгэх сургуулийн сургалтын төлөвлөгөө, багшийн хөгжлийг дэмжих сургалтад “Тэгш хамруулах сургалтад МХХТ-ийг ашиглах арга зүй”-н чиглэлийн хичээл (модуль) тусгах хэрэгцээтэй байна.
4. Сургалтанд ашиглагдаж буй ном сурах бичгийг зорилтот бүлгийн (хөгжлийн бэрхшээлтэй) хэрэгцээнд нийцүүлж, хүртээмжтэй байдлаар сайжруулах (аудио, видео, DVD, брайль, дүрс зураг гэх мэт) шаардлагатай.
5. Сургууль бүрийн Мэдээлэл зүйн кабинетийг тэгш хамруулан сургахад ашиглах тоног, төхөөрөмж, бусад хэрэгслээр өргөтгөх (дейзи цахим ном тоглуулагч, дэлгэц уншигч программ, цахим брайль төхөөрөмж) нь чухал.
6. Тэгш хамруулах, тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлын мэдээллийн сан бий болгох.
7. Бүсийн зайн сургалтын төвүүдээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг боловсролыг дэмжих зайн сургалт зохион байгуулах, нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэх.
8. Монгол хэл дээрх дэлгэц уншигч, өнгө, дүрс, дулаан, гэрэл, мөнгө таних тусгай хэрэгцээт программ хангамжийн хөгжүүлэлтийг дэмжих.
9. Бид “Хүн бүр ялгаатай” гэсэн зарчмыг ойлгож, тэгш хамруулах боловсролын талаарх хандлагаа өөрчлөх хэрэгтэй байна.

21

## Ашигласан материал


1. https://lawforum.parliament.mn/draft/75/
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль 2016.02
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр ЗГ, 2017 321 дүгээр тогтоол
4. Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо Боловсрол, шинжлэх ухаан, оюуны өмч 2020
5. МУБИС БоСС ТХБТэнхим Тэгш хамруулах ба тусгай хэрэгцээт боловсролын бодлого, үйл ажиллагаа ЭШХ-ын эмхэтгэл 2021
6. Л.Мөнхтуяа “Цахим сургалтын бэлэн байдлыг эргэцүүлэхүй” Багшийн хөгжил сэтгүүл 2020 №4
7. Л.Мөнхтуяа “XXI зуун ба сургалтын чиг хандлага” Боловсролын салбар дахь зайны сургалт болон онлайн платформ”-ын дэвшил, туршлага, арга зүй ОУ-ын ЭШХ 2020.12
8. https://www.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Census2020-Main-report.pdf&ln=Mn
9. http://itpd.mn/article/119
10. https://www.meds.gov.mn/?p=7377
11. Нээлттэй нийгэм форум, Эрдэм ССХ Боловсролын салбарт коронавируст цар тахлын үзүүлж буй нөлөөлөл 2020
12. Э.Хэнмэдэх Тусгай хэрэгцээт боловсролын теле хичээлд хийсэн дүн шинжилгээ бакалаврын зэрэг горилсон дипломын ажил

Удирдсан багш Л.Мөнхтуяа 2020 он

13. https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000373721_mon
14. https://gogo.mn/r/3xkw7
15. http://daisy-upl-mongolia.blogspot.com/2011/06/booksense-x-daisy.html
16. https://news.mn/r/2205308/


22

АНХААРАЛ ХАНДУУЛСАН ТА БҮХЭНД БАЯРЛАЛАА.

23